

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв, төслийн нэгж нь Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжуудын их засвар, гадна тохижилтын ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх тухай санал ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Бэрхийн ордод суурилсан “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгжийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, тус ордыг түшиглэн далд уурхайн музей бүхий эрдэс баялагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв байгуулах замаар Монгол улсад уул уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн жишиг тогтоох, түүнийг олон улсын хэмжээний жишигт хүргэх, мөн түүнчлэн Монгол улсын Зүүн бүсийн түүхэн аялал жуулчлалын маршрутад оруулах, шинээр ажлын байр бий болгоход чиглэгдэнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ.

- ТӨХБАҮХАТухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан нотлох баримт
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2016, 2017, 2018 (Сүүлийн гурван жилд заагдсан зөвлөх үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Хүдрийн далд уурхайн ашиглалт болон барилгын зураг төсөл, гадаад, дотоод интерьерын чиглэлээр зураг, төсөл боловсруулах чадвартай боловсон хүчинтэй байх
- Хөдрийн далд уурхайн ашиглалт болон барилгын зураг төсөл, гадаад, дотоод интерьерын чиглэлээр зураг, төсөл танилцсан туршлагатай байх

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Гадаадын этгээд оролцох эрхгүй.

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө дор дурдсан хаягаар ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ **2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 15:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

“Монголын далд уурхайн сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв”

Хаяг: Улаанбаатар хот-51, ш/х-002

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо,

“Монголросцветмет”ТӨҮГ-ын байр, өрөө: 103

И-майл: miningmuseummon@gmail.com